

С.БУЯННЭМЭХИЙН УРАН БҮТЭЭЛ ДЭХ “ШИНЭ” БЭЛГЭДЛҮҮД

Г.Нандинбилиг

Хураангуй: Тус өгүүлэлд Монголын шинэ цагийн бичгийн утгач С.Буяннэмэхийн далд утгат шүлгүүд болон зарим үлгэр өгүүлэл, жүжгийн зохиолуудыг задлан шинжилж, шинэ соёл суртлыг уншигчид хүргэх зохиолчийн зорилго хийгээд шинэ бэлгэдлүүдийг бүтээсэн туршлагыг тодорхойлон, гол бэлгэдлүүдийг тайлан тайлбарласан болно.

Түлхүүр үг: *С. Буяннэмэх, бэлгэдэл, далд утга, уран зохиол, шүлэг, жүжиг*

Бэлгэдэл гэдэг бол зохиолчдод агуу их санааг илэрхийлэх, эсвэл үйл явдал, дүр, сэдвийг холбох боломжийг олгодог. Аливаа ард түмний оюун сэтгэлгээнд хоногшин тогтсон уламжлалт бэлгэдлүүдийг шинэ санаагаар баяжуулан оновчтой ашиглах замаар аугаа зохиолчид нийтийн үзэл ухамсрыг өөрчилсөн хүчирхэг зохиолуудаа туурвисан байдаг билээ. Хувьсгалын эхэн үеийн манай зохиолчид үндэсний аман зохиол, эртний бичгийн уран зохиолд өргөн ашигладаг уламжлалт бэлгэдлийн зэрэгцээ шинэ үзэл суртлыг уншигчид дамжуулах, шинэ соёлыг таниулах зорилгын үүднээс шинэ соёлын бэлгэдлүүдийг уран бүтээлдээ өргөн ашиглаж байжээ.

Монголын шинэ цагийн бичгийн утгач С.Буяннэмэхийн бүтээл туурвилын хэлний үр нөлөөг судлан тодруулахын тулд бид энэ өгүүлэлдээ түүний далд утгат шүлгүүд болон зарим үлгэр өгүүлэл, жүжгийн зохиолыг сонгон авч, зохиолдоо бэлгэдлийг хэрхэн ашигласныг шинжилж үзэх замаар монголын уран зохиолд түүний оруулж ирсэн шинэ бэлгэдлүүдийг судлан тодорхойлохыг зорилоо. Тодорхой зохиолчийн уран бүтээл дэх янз бүрийн бэлгэдлүүдийг тайлан тайлбарлах нь зохиолчийн зорилго хийгээд зохиолын хэлний үр нөлөө, уран зохиолын арга барилыг тодруулахад тусална.

С.Буяннэмэхийн уран бүтээлийг олон талаас судлан шинжилсэн хэдий ч монголын уран зохиолд түүний оруулж ирсэн шинэ бэлгэдлүүдийг тодорхойлсон судалгаа олонгүй. Монгол аман зохиол, эртний уран зохиол дахь бэлгэдлийг судалсан профессор С.Дулам¹ 2016 онд “ХХ зууны монгол уран зохиол судлалын эрдэм шинжилгээний хурал-II Даяаршил ба нутагшил” Олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн “Орчин үеийн уран зохиолыг тэмдэг зүй- бэлгэдэл зүйн үүднээс судлах нь” нэрт илтгэлдээ Д.Нацагдоржийн “Хөдөө талын үзэсгэлэн”, С.Буяннэмэхийн “Уран гоо охины үлгэр” хоёрыг индекс болоод хөрөг бэлгэдлийн талаас судлахын хамтаар орчин үеийн уран зохиолын бэлгэдлийг судлахын чухлыг сануулсан байна.

С.Буяннэмэхийн уран бүтээл дэх бэлгэдлүүдийг шинжилж үзээд бид ерөнхийд нь домог зүйн хийгээд эд зүйлсийн бэлгэдэл гэсэн хоёр талаас ангилан судалж, тайлан тайлбарлаж байна. Домог зүйн бэлгэдлүүдийг дотор нь монгол болоод энэтхэг домог зүйн бэлгэдэл, эд

¹ Дулам С (2016). Орчин үеийн уран зохиолыг тэмдэг зүй- бэлгэдэл зүйн үүднээс судлах нь. – ХХ зууны монгол уран зохиол судлалын эрдэм шинжилгээний хурал-II Даяаршил ба нутагшил” Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэл. МУШУА, ХЗХ. БНХАУ ӨМИС., Эрхэлсэн С.Байгалсайхан, Б.Мөнхбаяр. Улаанбаатар.

зүйлсийн бэлгэдлийг дотор нь монгол, хятад, манж болон өрнийн соёлын эд зүйлс, шашны соёлын эд зүйлс гэхчлэн ялгах боломжтой.

Нэг. Домог зүйн бэлгэдэл

С.Буяннэмэхийн “Гайхамшигт байдал” өгүүллэг дэх бэлгэдэл: Олон зууны тэртээгээс эртний домгийн бэлгэдэл утга зохиол, урлагт өргөн тархсан байсан бөгөөд зарим нь шашны утга агуулгаар баяжин хөгжиж, тэдгээр домгийн болон шашны бэлгэдлүүд нь орчин үеийн бүтээлүүдэд ч шинэлэг байдлаар амилж байдаг.

Монголын уран зохиолд эртний домгийн сурвалжтай бөө мөргөлийн бэлгэдэл болоод бурхны шашны бэлгэдэл хоёр зэрэгцэн байдаг. С.Буяннэмэхийн “Гайхамшигт байдал” өгүүллэгт “Зуны зургаан сарын нэгэн өдрийн тунгалаг сайхан нар, ариухнаар сэржигнэсэн цэцгийн хур, таван өнгийн гайхамшигт солонго зэрэг байгалийн үзэгдлээр бэлгэдэл бүтээж, “хөндий их орчлонгийн дотор түгээмэл их улаан туяа татаад хүний ертөнцийн оронд гайхамшигт байдал болон зохилдов” (Буяннэмэх, 1968: 65) гэхчлэн нарны гэрэл туяа, солонгын өнгө, цэцгийн хур гэх мэт байгалийн үзэгдлийг тэнгэршүүлэн бэлгэдэх монгол домог зүйн уламжлалыг бүтээлчээр шинэчлэн хэрэглэжээ.

Цаашилбал “...алтан нарны эрдэнийн туяа агаар буданг нэвтлэн харваж...таван өнгийн үүлэн дундаас нэгэн их гэрийн чинээ том шувуу гарч ирэв, хамаг биеэс нь улаан гэрэл цацарсан, явах чимээ нь их ... Ажиглан үзвээс үнэхээр нэгэн их гайхамшигтай шувуу мөний тул өвгөн яаран хэлрүүн: -Энэ магад бурхны элч, тэнгэрийн шувуу гарди галбингаа гэгч буй заа. Өвгөн би бурхан тэнгэрт биширсний ачаар энэ шувуу бидэнд харагдсан буй заа.... энэ магад тэнгэр бурхнаас ертөнцийн оронд ном тараав хэмээн яаран ...сөгдөн мөргөж, тэрхүү номыг сайтар эвхээд өвөрт агсан “Алтангэрэл” судрын баринтагтаа хамтатган агуулаад, ямар ч эрдэнэ олсноос илүүгээр баярлан...” (Буяннэмэх, 1968: 66-67) гэхчлэн нисдэг тэрэг хэмээх шинэ соёлын дүрийг эртний Энэтхэгийн домог зүйн Вишнү тэнгэрийн хөлгө -гарди хэмээх домгийн шувуутай, түгээж буй шинэ сонин хэвлэлээ буддын шашны “Алтангэрэл” судартай адилтган бэлгэдэх зэргээр уламжлалт бэлгэдлийн тогтсон санааг шинэ итгэл үнэмшилд шилжүүлэн хэрэглэжээ.

Мөн түүнчлэн жил, сар, өдөр, цагийн бэлгэдлийг эрхэмлэн үздэг монгол уншигчдад “... номыг авч их дуугаар уншсан нь: Энэхүү аргын долоон сарын арван нэгний өдөр бол манай монголчуудын ардын эрхт Бүгд Найрамдах улсын тулгуурыг байгуулсан их баярын өдөр бөгөөд энэ өдрийн утга чанар нь ...ард түмэн эрх чөлөөгөө олж, эрдэм соёлын гэгээн замд давшихын үүд нээгдэж, хэдэн зуун жил харанхуй мананд төөрснөөс тонилоон гэтэлгэхийн мөрийг олсон нь...жилээс жил тэмдэглэвэл зохино гэж уншжээ. Ардын намын нисдэг тэрэг олон түмэнд бичиг тараасан ба ард түмний эрх чөлөөг дэлгэрүүлсэн нь энэ өдөр ажгуу...” (Буяннэмэх, 1968: 67) хэмээн тус зохиолоороо “шинэ өдөр”-“шинэ эхлэл” гэсэн бэлгэдэл санааг дагуулан бас нэгэн шинэ өдрийн бэлгэдлийг бүтээхийг зорьсон байна.

Далд утгат шүлэг, зохиол бол бэлгэдэлт дүрслэлийн арга барилтай нягт холбоотой. С.Буяннэмэх нар далд утгат шүлгийн өвөрмөц хэлбэрийг бүтээсэн нь далд утгат шүлгийг тайлсан шүлэг юм. Жишээлбэл, Монголын зохиолчдын байгууллагын үндэс болсон “Уран зохиолчдын бүлгэм”-ээс эрхлэн хэвлүүлсэн “Уран үгсийн чуулган” эмхэтгэл номын 120-127 дугаар талд “Тайлбарлуулахыг эгээрсэн шүлэг” хэмээх нэгэн бүтээлийг хэвлэжээ.

С.Буяннэмэхийн нэгдүгээр бадгийн эхний хоёр шад шүлэгтээ

“Өмнөд огторгуйн пад харанхуй харын дунд
Нэгэн зурвас дэнгийн гэрэл салхин дор бүргэлзмүй”

(Уран үгсийн чуулган, 19-р он: 120)

хэмээн харанхуйг гийгүүлэгч дэнгийн гэрлээр өөрчлөлтийг бэлгэдэн үзүүлэхийн хамтаар түүнийг өдөөж буй хүчийг “салхин” хэмээн бэлгэдсэн бол гурав дөрөвдүгээр шад шүлэгтээ дарлалыг “гаслангийн дуун сонсогдох” гэж, дарлалыг эсэргүүцэн босох олны хүчийг “гарын

шидамыг чангатгамуй” хэмээн нударга зангидсан гарыг дүрсэлж, нэгэн шинэ бэлгэдлийг бүтээжээ.

С.Буяннэмэхийн хоёрдугаар бадаг шүлэгт

“Мянган жилийн ховдог сэтгэлийг хэвлийд өвөрлөөд
Түмэн газрын цагаан хэрмийг сандайлан суутал
Европын хар аалзны шүлсэн дор бүслэгдэж
Японы шар ирвэсийн шүдэн дүр зуугдмуй”

(Уран үгсийн чуулган, 19-р он: 120-121)

хэмээн хөрш зэргэлдээ хоёр үндэстний харилцааны он удаан жилийн түүхийн ээдрээ нугачааг “түмэн газрын цагаан хэрэм”-ээр бэлгэдсэн байна. Түүнчлэн өрнө дахины санаархлыг шүлсээрээ урхи торыг нэхэн зэхэж, олзоо барьдаг “хар аалзны шүлсэн” гэж, японы халдлагыг “шар ирвэсийн шүдэн” гэхчлэн амьтны бэлгэдлийг ашиглан үзүүлсэн байна.

“Зураг ба шүлэг” хэмээх Буяннэмэхийн гарын үсэгтэй гар бичмэлийг хавсарган хэвлэснээс үзвэл нэгэн ногоон өнгөт модны цэцэг навчис дэлгэрсэн мөчир дээр шар ногоон өнгийн тоть шувууг суулган зурж, өмнө зайд “Модны дунд бодь мод...” гэсэн нэгэн бадаг, дөрвөн мөр, таван нугалбар, долоон үгт шүлгээ монгол гар бичмэлээр бичихдээ нэгдүгээр шадьг ногоон, хоёрдугаар шадьг шар, гуравдугаар шадьг хөх, дөрөвдүгээр шадьг улаан өнгөөр ялган бичсэн нь дөрвөн цагийг өнгийг бэлгэдэх мэт сэтгэгдэл төрүүлнэ.

Модны дунд бодь мод бүжиглэн найган суухуй дор (ногоон)
Шувууны доторх тоть шувуу баясан дуулан ирээд (шар)
Таван өнгийн өд сөд нь навчин хавтаснаа намирч (хөх)
Нэгэн зурвас яруу үг нь мянган ланд таацмуй (улаан)

(Уран үгсийн чуулган, 19-р он: 120)

Тухайн шүлгийг тайлсан хүн хувьсгалын утгаар тайлсан ч бичвэрийн далд утга гэдэг бол олон давхар байж болно. Шүлгийн ногоон өнгөт эхний шад нь моддын дундаас бодь модыг, шар өнгөт дэд шад нь бодь модонд суух тоть шувууг, хөх өнгөт гутгаар шад нь түүний таван өнгөт өд сөдийг онцолж, улаан өнгөт дөтгөөр шад нь яруу найргийн нэгэн шадьг мянган лангаар үнэлдэг. Ерөөс монгол домог зүйд мод хэмээх ургамал бол үзүүр нь тэнгэрийн оронд тэмүүлж, үндэс нь харанхуйн оронд хавж, их бие нь нартад оршихын учраар гурван ертөнцийг бэлгэддэг бол буддын домог зүйд бодь мод нь Будда гэгээрлийг олсон ариун газрын тэмдэг, бясалгал гэгээрлийн бэлгэдэл болдог учиртай. Харин тоть шувуу нь хүн төрөлхтний гэршүүлж тэжээсэн анхны шувуу бөгөөд өд сөд нь таван өнгөөр хувирч харагддаг, хүний хэлснийг давтан хэлдгээрээ дэлхий дахины утга зохиолд хүний мөн чанарын тусгал, зан харилцааны толь, үнэн мөний бэлгэдэл болдог байна. Эдгээр бэлгэдлээс нэгтгэн үзвэл, тус шүлгийн далд утга нь яруу найргийн үнэ цэн буюу гэгээрэл хийгээд үнэн мөнд хүрэх чанарыг бэлгэдэж буй бололтой.

Цаашилбал, Магсар авгайн хариу тайлбарлуулахыг хүсэж ирүүлсэн гурван зүйл шүлгийн нэгдүгээр шүлэгт “Ази тивийн дунд оршиж асан гарди шувуун...” хэмээн Монгол улс үндэстнийг гарди шувуугаар бэлгэдсэн далд санааг С.Буяннэмэх тайлахдаа

“Ази тивийн дунд Монгол. Монголын дундаас Чингисийн цол
Анхны цагт гардиас илүү газар бүр нэвтэржүхүй
Хар далай, Каспийн далай хамаг нийтийг зовоож,
Харин сүүлд хятад шувуу, манж гөрөөчдөд баригджухуй”

(Уран үгсийн чуулган, 19-р он, 126)

хэмээн монгол үндэстнийг дэлхийд таниулсан Чингис хааныхаа нэр цууг гарди шувуугаар бэлгэдэхийн хамтаар гардиас ч илүү гэж хэлсэн нь шинэ бэлгэдэл болж байна. Гаруда бол Хиндү болон Буддын шашны домог зүйгээс гаралтай, Вишнү тэнгэрийн хөлгө болдог хүн дүрст домгийн шувуу бөгөөд монгол домог зүйд жигүүртний хаан, тэнгэрийн хүчтэний бэлгэдэл дүр болж байдаг. Цаашилбал, Магсар авгайн шүлэгт “Цаст уулын цагаан барс цагаа болохоор шоргоолжинд идэгдэх үлгэр”-ийн санааг “шувуудын сүрэг гөрөөчдөд олзлогдох”

хэмээн хэлснийг С.Буяннэмэх тайлбарлахдаа хятад шувуу, манж гөрөөчин хэмээн тодотгож, үндэсний түүхэн ухамсрыг сэрээх гэсэн зохиогчийн зорилго ч тод харагдаж байна.

Магсар авгайн удаах бадагт архи дарсанд согтуурсаар улсаа алдсан гашуун түүхийг “зүүд нойр”-оор үзүүлснийг С.Буяннэмэх тайлбарлахдаа шашинд гүнзгий автсан гэсэн шинэ санааг нэмж, “бурхныг бясалгасан нь зүүдэлснээс өөрцгүй” гэж зүйрлэх замаар зүүдний хоосон чанараар бэлгэдэж байна. Цаашилбал, Магсар авгайн шүлэгт “Балгасны бясаа загатнан сэрээсэн боловч алсын ажлаас хожимдон хоцорсон нь гуниглалтай” хэмээн нойрноос сэрэх шалтгааныг балгасны бясаа хэмээн ёгтлон үзүүлснийг С.Буяннэмэх тайлбарлахдаа “Эвдэрхий Бээжин, цуцархай цагааны шунахай дарлан мөлжихүйд” гэж шууд хэлсэн байна.

Магсар авгайн гуравдугаар бадаг шүлэгт өвгөд хөгшдийн үе буюу хуучин суртлыг өөрчлөх хүчийг “хур салхин” хэмээн бэлгэдсэн бол С.Буяннэмэх тайлбарлахдаа “ноёд баяд” гэсэн үгээр ангийн санааг оруулахын хамтаар өөрчлөлтийн шалтгааныг “гамшиг барон ба хувьсгалын хөдөлгөөн” гэж гэж тодотгосон байна. Магсар авгай төгсгөлийн хоёр шаддаа өөрчлөлтийн дараах амар жаргаланг авчирсан хүчийг “хөвгүүдийн сайн авьяас” гэж хэлснийг С.Буяннэмэх “ардын хөвгүүний баатар зоригор” гэж хувьсгалын үзэл санаагаар баяжуулан бататгасан байна.

Хоёр. Эд зүйлсийн бэлгэдэл: Аливаа үндэстний уран зохиол нь эртний сонгодог романуудаас эхлээд орчин үеийн өгүүллэг зохиолоо хүртэл эд зүйлсийн бэлгэдлээр дүүрэн байдаг. Дэлхий дахины уран зохиолд хайр сэтгэлийг илтгэх романтик бэлгэдэл нь өргөст улаан сарнай цэцэг болон зүрх, хайрын бурхны харвасан сум, очир алмаз зэрэг олон бэлгэдлийг ашигладаг. С.Буяннэмэх ч мөн зохиолууддаа, таяг, гаанс тамхи, хөөрөг тамхи, хятад дэвүүр, талх, барилга, машин зам, нисдэг тэрэг, утас холбоо зэрэг харь соёлын болоод шинэ соёлын олон эд зүйлсийг бэлгэдэл болгон ашиглаж, өвөрмөц бэлгэдлүүдийг бүтээсэн байна.

С.Буяннэмэхийн “Их тэнгэрийн дүлий” өгүүллэгт шинэ соёлын зүйлийг таниулж, улмаар шинэ бэлгэдлийг бүтээх арга тод ажиглагдана. С.Буяннэмэхийн “Их тэнгэрийн дүлий” зохиолд энгийн нэгэн “талх” нь шинэ соёлын тэмдэг төдийгүй ажил хөдөлмөрийн үр шимийг бэлгэдэж байна. Мөн түүнчлэн талхыг “их тэнгэрийн дүлий” гэж нэрлэн шүтэх үйлдлээр ард олны бүдүүлэг харанхуй байдал, мэдэмхийрэгчдийг даган төөрөлдөгсдийг таниулж, улмаар талхыг хувааж зүсэх төлөөлөгчийн үйлдлээр үнэн мөнгийг шинжлэн таниулах үйл хэргийг бэлгэдэж, хэдэн хэсэг болж бутрах хатсан талхаар хуучин итгэл үнэмшил хагаран бутарч байгааг бэлгэдсэн байна.

“Их тэнгэрийн дүлий” өгүүллэгт мал ахуй эрхлэн ирсэн ард түмэн гурил гээчийг мэдэхгүй байгаад, анх талх үзэж буй тухай өгүүлэхдээ ард түмэн хэрхэн хоосон мухар сүсэгт хэрхэн автсан байгааг шоглон үзүүлдэг. Өгүүллэг эхлэхэд Сүхэндэй, Халцгай Гончиг, Донсуй Түвдэн гурав тэмээн хөсөг хөтөлж явтал шатны дуудай нь мултарч хараал ерөөл тавилцан бууцгааж, тэмээнийхээ хом шатыг чангалан засах болдог. Донсуй Түвдэн нь хуурай аргал хайж тэнэсээр хөндлөн харагдагч их зам дээр хүрч, машин тэрэгний дугуйн мөрийг анх анх үзэж их л сонирхон гайхаж байгаад нэгэн бөндгөр талж олж, эхлээд хожгор шар тос гэж бодтол шар тос биш, огт танихгүй зүйл байсан тухай, тэгтэл Халцгай Гончиг нь их мэдэгч болж, чухал эрдэнэ, “их тэнгэрийн дүлий” хэмээгч чухал эрдэнэ гэж итгүүлэн авч яваад, нутагтаа очсоны дараа Донсуй Түвдэнгийн гэрт хадаг яндарт ороон залж, мөргөж шүтэж, удалгүй хол ойрын хүмүүс эргэл мөргөл, тахил тавил болцгоож, өөрсдийн сүсгийн үүднээс эд мал, хөрөнгө зоорио өгсөөр, олноороо риди чадал, эрдэм гайхамшигтай гэж итгэж, асуудал шийдэхэд туслах арга болгож мунхраад байсан тухай, сүүлд харин төвөөс ирсэн төлөөлөгчийн ачаар энэ нь энгийн нэгэн талх гэгч зүйл байсныг мэддэг.

Тус өгүүллэгт олон зүйлийг бэлгэдэл болгон ашигласны дотроос хамгийн гол жишээ нь талх юм. Өгүүллэг эхлэхдээ “...түүний нүдэнд нэгэн том бөндгөр юм ам дээр хэвтэж байв. Донсуй Түвдэн их л гайхаж алгуур алхалсаар очив Үзвэл нэгэн хожгор шар тос ажээ. ...хожгор шар тосыг яаран очиж шүүрэн авч үзвэл харин маш хөнгөн бөгөөд дотор нь юу ч үгүй хөндий сав шиг байв” (Буяннэмэх, 1968: 54) гэж гардаг. “Нэгэн том бөндгөр юм”-ыг анх хараад Донсуй

Түвдэн “хожгор шар тос” гэж боддог. Мал аж ахуй эрхэлсэн нүүдлийн соёлт хүний хувьд шар тос нь идээний дээжийг бэлгэддэг бол тариалангийн соёлт үндэстэнд талх нь газар эхийн шим, хөдөлмөрийн шимийг бэлгэддэг. Тиймээс ч оросын ард түмэн тариалангийн хөдөлмөрийн шимийг талхаар бэлгэдэж, хүндэт зочноо талх, давс барин угтдаг. Зохиолч монголын уран зохиолд анх удаа талх хэмээх зүйлийг шинэ соёлын бэлгэдэл болгож оруулж ирсэн байна.

Зохиолч зохиолоо “Их тэнгэрийн дүлий” гэж нэрлэсэн нь юуг ч тэнгэрийн болгон шүтэж, үнэн мөнийг ялгаж таних мэдрэмжээ алдан, шашны мухар сүсэгт автахын уршгийг шоглохын хамтаар дүрийн зан суртахууныг егөөдсөн байна. Тэнгэрийн дүлий гэдэг бол монголын тал нутагт зуны улиралд газрын чийг татаж, мөөгний хүрээ даган ургадаг мөөгөнцрийн нэгэн зүйл билээ. Зохиолд халцгай Гончиг гэгч нөхөр энгийн нэгэн талхыг гайхамшигт нэгэн тэнгэрийн дүлий гэж эндүүрэн, “Энэ хэмээгч туйлын чухал эрдэнийн зүйл болой. Үүний нэр нь Их тэнгэрийн дүлий гэдэг болно. Үүнийг олж тахисан ямарваа хүмүүс буяны дээд, баяны зузааныг эдэлж, насан жаргах, үр ач дэлгэрч, дээдийн мөрийг олох сайн заяатай болдог болой” (Буяннэмэх, 1968:56) хэмээн мэдэмхийрч, хадаг яндарт ороон тахиж, олон түмэнд худал ярьж, мунхарсан олныг ашиглан, хялбар аргаар хөрөнгөжиж байгаа нь монгол үлгэрийн үнэг чоно хоёр гүзээтэй шар тос олсноор өөрсдийн өлөн ховдог, заль мэхт зан суртахуунаа хэрхэн илчлэн харуулдгийг санагдуулна. Тодруулж хэлбэл, ардын үлгэрт хүний гэнэн тэнэг, өлөн ховдог зан суртахууныг хээрээс ховор чухаг олз олох мөрөөдлөөр илчлэн харуулдаг ардын үлгэрийн аргыг энд боловсруулан хэрэглэсэн байна.

Мухар сүсэгт автсан ард олныг сэнхрүүлэн таниулагч бэлгэдэлт дүр нь “Төвөөс ирсэн төлөөлөгч” болж байна. Төвөөс ирсэн төлөөлөгч “их тэнгэрийн дүлий”-гэгч нь идтэй шидтэй зүйл бус энгийн нэгэн талх болохыг олонд илчлэн харуулж, хутгаар зүсэж хэдэн хэсэг болгон үзүүлснээр ард олны мухар сүсэг буюу хуучин итгэл үнэмшил нь “хэдэн хэсэг бутарч” байгааг бэлгэдэн үзүүлсэн. Мөн түүнчлэн төвөөс ирсэн төлөөлөгчийг “умар зүгээс чухамхүү үнэн тэнгэрийн дүлийг авчирсан гайхамшигт хүн...” гэхчлэн зар тараадаг хэсэг буй. Энэ хэсэгт умар зүг бол үнэний зүг мөн гэсэн далд санаа бүхий бас нэгэн шинэ зүгийн бэлгэдлийг бүтээсэн байна.

Утга зохиол, урлагт аливаа замыг үзүүлэх нь олон бэлгэдэл утгатай байдаг. Зохиолч тус зохиолдоо нэгэн шинэ бэлгэдлийг хэрэглэсэн нь машин тэрэгний дугуйн мөр бүхий “их зам” юм. Өгүүллэг эхлэхэд Сүхэндэй, Халцгай Гончиг, Донсуй Түвдэн гурав тэмээн хөсөг хөтөлж явтал шатны дуудай нь мултарч хараал ерөөл тавилцан бууцгааж, тэмээнийхээ хом шатыг чангалан засах болдог. Тэгээд Донсуй Түвдэн нь хуурай аргал хайж тэнэж яваад, хөндлөн харагдагч их зам дээр хүрч, машин тэрэгний дугуйн мөрийг анх үзэж их л сонирхон гайхаж байгаа хэсэг байдаг. Зохиолч энэ хэсэгт маш гүн санаа бүхий далд утгыг хэдэн давхар бэлгэдлээр гаргасан байна. “Бидний аяллын хуучин бүдэг жим энд хүрээд дуусаж байна” гэсэн санааг “тэмээн хөсгийн шатны дуудай нь мултарч унасан” явдлаар бэлгэдэн үзүүлсэн бол “бидний өмнө шинэ зам гарч ирлээ” гэсэн санааг “машин тэрэгний дугуйн мөр бүхий их зам хөндлөн тохиолдож” буйгаар бэлгэдэн үзүүлсэн байна.

“Бүтэлгүй Гомбын маргааш” өгүүллэг эхлэхдээ нэгэн хот айлын дүр зургийг өгүүлээд, дараа нь баруун өмнө талын гэрт төвлөрнө.

“Бүргэд толгойн энгэрт нэгэн хэсэг айл харагдана. Хамгийн баруун өмнө талын гэр бол маргааш хэмээх үлгэрийн эзэн сууна... гэрийн эзэн Гомбо нь залхуугийн өвчтэй. Нэг өдөр түлээ ховордоход эх нь хэлрүүн:

Ойроос тэнгэр муухай болох байдалтай байна. Түлэх түлш огт үгүй төгссөн шүү. Чи эртхэн түлээнд яваад ирэхгүй юу гэв

Гомбо тэнгэр өөд харж нэлээд удсаны хойно

- Энэ өдөр үхрээ бариагүй яаж явах вэ, маргааш олъё доо гэв. Маргааш гэдэг удалгүй ирдэг тул өглөө эрт үхрээ бариад уяв. Тэргээ хөллөх болоод байтал Гомбо хараал тавьсаар орж ирлээ. Эхнэр гайхаж

- Юу болов? гэхэд

-Юу болох юу байх вэ. Тэрэгний дугуй өрөөсөн нь эвдэрсэн байна... маргааш л явж үзэхээс дээ гэв” (Буяннэмэх, 1968: 50).

Зохиолч хот айлын баруун өмнө талын гэрийг сонгон өгүүлсэн нь учиртай. Уламжлалт хот айлын баруун талд хамгийн ахмад настай айлын гэр байдаг ба нүүдэл суудал товлох, хонины ээлжийг хуваарилах гэх мэт аливаа удирдах, шийдвэр гаргах эрх үүргийг баруун гэрийн эзэн гаргадаг. Тус зохиолд баруун гэрийн эзэн Гомбыг эхтэйгээ хамт амьдардаг залуу нэгэн байгаагаар үзүүлэх ба хот айлыг удирдах нь байтугай галын түлээгээ ч бэлтгэхгүй залуурч байна. Монгол соёлд галын түлээгээр гадаах нь гэртээ орсон эсэхийг бэлгэдэж “*Залхуугийн гадаа түлээгүй, залгидгийн гадаа малгүй*” гэж хэлэлцдэг уламжлалыг тусгасан байна.

Мөн түүнчлэн тус зохиолд Гомбыг эхтэйгээ хамт амьдардаг гэж үзүүлэх ба түүний эхнэр ч үгүй байдлыг үзүүлэхдээ зохиолч мөн л өмнөх зохиолын нэгэн адил тэрэгний дугуй”-ны бэлгэдлийг ашиглаж, “өрөөсөн дугуй нь эвдэрсэн тэрэг”-ээр бэлгэдэн үзүүлсэн байна.

“Жинчин Пүрэвийн жигтэй” өгүүллэгт хуучин цаг халагдаж, шинэ цаг ирж байна гэсэн санааг илэрхийлэхдээ зохиолч Улаанбаатар хот, хуучин Хүрээ хоёрыг эсрэгцүүлэн “Улаанбаатар гэдэг чинь тэнгэр тулаад байна...өчнөөн төчнөөн, давхар давхар, өндөр өндөр, их их байшингууд” пиг дүүрэн болоод оройг нь харах гэсэн малгай ойчоод сандрав. Түүний дэргэд манай өнөөх сайхан гэдэг хүрээ маань хэдэн өвс дэрс хатгачихсан юм шиг болоод байна” (Буяннэмэх, 1968: 45) гэхчлэн өндөр байшингаар хотын бүтээн байгуулалтыг бэлгэдэжээ.

Цааш нь “Пүрэв хэлрүүн: -Үгүй үнэхээр жигтэй юм. Үхсэн жигтэй юм ч бус үнэндээ шив шинэхэн төрсөн жигтэй юм байна. Улаанбаатар гэдэг чинь тэнгэр тулаад байна гэхэд болмоор байна. ...өчнөөн төчнөөн, давхар давхар, өндөр өндөр, их их байшингууд пиг дүүрэн болоод оройг нь харах гэсэн малгай ойчоод сандрав. Түүний дэргэд манай өнөөх сайхан гэдэг хүрээ маань хэдэн өвс дэрс хатгачихсан юм шиг болоод байна. Түүний хажуугаар яваа хүмүүс нь хадны ёроолд гүйж яваа хорхой шиг байна гэв” (Буяннэмэх, 1968: 46) гэхчлэн зохиолч тэртээ зуу шахам жилийн өмнө бичсэн нь орчин үеийн өрнийн утга зохиолд орчин үеийн хүнийг цементэн “ширэнгэн ой”-н доторх өчүүхэн хорхой болгон үзүүлдэг онолын түвшинд сэтгэж буйг тэмдэглүүштэй байна.

Зохиолч тус зохиолдоо өөр нэгэн шинэ бэлгэдлийг хэрэглэсэн нь “цахилгаан гэрэл” юм. Тэрээр аливаа сайн сайхныг нарны гэрлээр бэлгэдэх уламжлалт бэлгэдлийг цахилгаан гэрлээр сольж, “Хүний ухаан эрдмийн хүчээр үйлдэн бүтээсэн цахилгаан гэгч” хэмээн хүний оюун ухаан болоод мэдлэгийн хүчийг цахилгаан гэрлээр бэлгэдсэн шинэ бэлгэдлийг бүтээжээ. Жишээлбэл, тус зохиолд “...Би тэр олон өнгө бүрийн олон сайхан ногоон, цагаан, ягаан байшингуудыг сонирхон харж явтал орой болсныг мэдсэнгүй, гэнэт хав харангуй болов. ...гэв гэнэт цахилгаан цахих шиг болоод өдөр шиг тунгалаг гэрэл их хотыг дүүрэн гэрэлтүүлж зам мөр байтугай тоос шороо ч танигдах болов...Ер нь тэнгэрийн орон гэдэгт гарчхаад зүүдэлж яваа юм биш байгаа гэж санаагц сүсэг төрөв...Энэ бол цахилгаан гэрэл гэв... Одоо тэр тэнгэр дээр гялсхийдэг цахилгаан гэж үү дээ гэв.... тэр хүн инээн хэлрүүн: - Тийм тийм энэ нь үнэндээ тэнгэрийн цахилгаан бус боловч хүний ухаан эрдмийн хүчээр үйлдэн бүтээсэн цахилгаан гэгч бөгөөд... гэв” (Буяннэмэх, 1968: 48) хэмээн бичжээ.

С.Буяннэмэх “Харанхуй засаг” жүжгийн зохиолдоо эд зүйлийн бэлгэдлийг ашиглан, илүү гүн гүнзгий утгыг илэрхийлэх боломж зохиолчдод олддог. С.Буяннэмэхийн “Харанхуй засаг” жүжигт хатны харь соёлын нөлөөнд автсан байдлыг үзүүлэхэд дэвүүр болон гаанс тамхийг хэрэглэсэн байна. Дэвүүр бол хятадын соёлын зүйл бөгөөд хятадын ший янгууны дууч эмэгтэйчүүдийг бэлгэддэг. Манжийн ноёрхлын үед дэвүүр нь монголын хүрээний соёлд нэвтэрч, хүрээний зарим бүсгүйчүүдийн чамирхал болж байжээ. Жүжиг эхлэхэд “...Баялаг феодалын гэр өргөө үзэгдэж, зүүн орны гоёмсог түшлэг дээр нэгэн энгэсэгтэй үзэсгэлэнт бөгөөд ихэмсэг хатан хүн хажуулдан хэвтэж, толгойн орчим Цэцэг хэмээх үзэсгэлэнт аягач сууж, дэвүүр барин хатныг алгуур дэвүүрдэнэ. Бас нэгэн аягач хүүхэн гаансанд тамхийг нэрж, хатанд барьж татуулна. Бас нэгэн аягач цай хийж байна. Нөгөө этгээдэд нэгэн хуурч

хөгжимдөн байх бөгөөд үүний орчим нэгэн дууч хүүхэн дуулна. Хаалганы орчим хоёр чийрэг хиа зогсож байна... Цэцэг дэвүүрдсээр байж, дэвүүрийг газар алдаад... Хатан дэвүүрийг авч, дэвүүрээр Цэцэгийн хацрыг занчина..Цэцэг дэвүүрийг авч дахин дэвүүрдэнэ.” (Буяннэмэх, 1968: 180) гэхчлэн дэвүүрээ хүнээр дэвүүлж, гаанс тамхиа хүнээр нэрүүлэн татаж байгаагаар үзүүлж байна.

Урлаг уран зохиолд эмэгтэйчүүдийг хөнгөн хийсвэр зантай юм уу уйдаж ганцаардсан, эсвэл бусдын нөлөөнд автсан байдлыг үзүүлэхдээ архи тамхитай холбож үзүүлдэг. С.Буяннэмэх тус жүжигтээ хатныг гаанс тамхи татаж буйгаар үзүүлсэн нь түүнийг харь соёлын нөлөөнд автсан болохыг илтгэн харуулж байна.

Зохиолч “Марал Шарын жүжиг”-тээ мөн Шар хүүхнийхээр эргэлдэгч эрчүүдийг лам, харгүй ямагт тамхи татаж, гартаа гаанс барьж юм уу гаансаа цохиж байгаагаар үзүүлдэг.

Маралын аав Билигт өвгөн бол урт сахалтай, таягтай тулж явдаг ба хөөрөг гарган тамхи татаж байдаг. Таяг бол олонх тохиолдолд тухайн дүрд бусдын тусламж дэмжлэг хэрэгтэй байгааг бэлгэддэг. Цагаан таяг нь дэлхий дахинд хараагүй хүнд туслахыг уриалсан утгыг бэлгэддэг бол францын уран зохиолд дэгээ таяг нь чинээлэг болоод хөнгөмсөг эрчүүдийг бэлгэддэг. Харин “Марал Шарын жүжигт” Билигт өвгөнийг таяг тулдаг, сахлаа шувтардаг үйлдлээр нь түүний өндөр насыг бэлгэдэн үзүүлэхийн хамтаар таяг нь түүнийг эхнэрээ алдаж, амьдралд түшиг тулгуур хэрэгтэй болсныг бэлгэдэж байна. Тэгээд түүний гол түшиг тулгуур болох охиндоо эрдэм сурахыг ихэд хичээнгүйлэн захиж байгаагаар үзүүлдэг.

Монгол соёлд хөөрөг нэвтрээд он удаан цаг хугацаа өнгөрөхөд хөөрөг тамхи нь мэндчилгээний соёлын салшгүй хэсэг болж үлдсэн бэлгэдэлтэй. Тус жүжигт Билигт өвгөний хөөрөг тамхиар өвгөн настай хүний өөрийгөө тайтгаруулах арга зуршлыг үзүүлэхийн хамтаар өмнөх цаг үеийн им тамга болгосон байна.

Хоёрдмол утгатай сэтгэл хөдлөлийг дүрслэхийн тулд зохиолд биет зүйлсийг үр дүнтэй ашиглах нь зохиолчоос өндөр түвшний ур чадварыг шаардана. С.Буяннэмэхийн “Марал Шарын жүжиг”-т эрдэм ном сурахын чухлыг захиж сургах эцгийн сургаал, Шар бүсгүйн садар самуунд дагуулах явуулга хоёрын өмнө тулгарсан Марал бүсгүйн сэтгэл хөдлөлийн хоёрдмол байдлыг илэрхийлэхдээ зохиолч ном ба толь гэсэн хоёр жижиг хэрэглэлийг гартаа ээлжлэн барьж байгаа үйлдлээр үзүүлсэн нь амжилттай болжээ.

С.Буяннэмэхийн “Марал Шарын жүжиг” эхлэхэд “Нэгэн хогшил зассан бүрэн төгс үзэсгэлэнтэй гэр байх бөгөөд нэгэн бага хүүхэн бичиг үзэж дорогш харан ...сууна” (Буяннэмэх, 1968: 202) гэхчлэн Марал бүсгүй ном бичиг үзэж суугаагаар үзүүлдэг. Зохиолчийн зүгээс эмэгтэй дүрээ ном уншиж буйгаар үзүүлсний зорилго бол эмэгтэйчүүдэд зохиолын дүрээрээ дамжуулан нөлөөлөх зорилготой гэдэг нь тодорхой бөгөөд тиймээс ч “Энэ гэгээн засгийн авралаар эрдэмтэй болбол хүү минь дээш дэвшиж дэргэдхээ гийгүүлэх чинь ойрхон шүү” хэмээх охиноо сургах аавын үгээр санаагаа баталдаг.

Хамгийн сонирхолтой нь дараагийн хоромд Марал бүсгүйг гартаа толь барьж үс гэзгээ засан байгаагаар үзүүлж, энэ үйлдлээ бүр ааваасаа нууж байгаагаар “...нэгэн толь авч өмнөө тавин үс гэзгээ засан суутал гэнэт үүдний гадна хүн ханиаж ирэх чимээ гарна. Хүүхэн яаран толио нууж, бичгээ аван уншин байтал нэгэн өвгөн орж ирээд таягаа тавин дээш сууж, малгайгаа авч тавин, сахлаа шувтарч, бас өврөөсөө тамхины хөөрөг гаргаж тамхи татан суугаад хэлнэ” (Буяннэмэх, 1968: 202) гэхчлэн үзүүлсэн байна. Толь бол бодит байдлын тусгалыг үзүүлдэг. Хүн толинд харахдаа өөрийгөө хардаг. Дэлхий дахины домог зүйд толь нь бодит ертөнц ба түүний тусгал хий биеийг харуулж, сүнстэй холбогдох хаалга гэж үздэгээс хүн нас барахад толийг бүтээдэг дом ч элбэг байдаг. Тодруулж тайлбарлавал толь нь домог зүйд ухамсарт оюун ухаан ба ухамсаргүй оюун санааны хоорондох босгыг бэлгэддэг. Толинд харснаар хүн өөрийн ухамсаргүй байдлын гүн рүү харж болно. Тиймээс зохиолчид толь хийгээд толины дүрсийг урлаг, утга зохиолд ямагт бэлгэдлийн үүргээр хэрэглэж, ухамсар ба далд ухамсрын аль алинд нь утга учиртай болгодог. С.Буяннэмэх “Марал Шарын жүжиг”-тээ Марал бүсгүйн дүрийг

таниулахдаа толины бэлгэдлийг ашигласан байна. Залуу бүсгүй өөрийгөө тольдож байснаа хүн ирэхээр толио нууж байгаа нь залуу бүсгүйн гоёх хүсэл, далд ухамсрын хүслийг илэрхийлжээ. Нарцисс болон Фаустаас ялгаатай нь толинд мэдээж үзэсгэлэнтэй залуу эмэгтэйг харж байгаа. Гётегийн “Фауст” жүжигт Фауст толиноос өөрийнхөө шууд тусгалыг олж хардаггүй, харин өөрийн ухамсарт дүр төрхөө алдсан, дахин залуу, эрч хүчтэй болох гэсэн хүсэл буюу далд ухамсрын далд ухамсрын тусгалыг олж хардаг. Үүний нэгэн адилаар С.Буяннэмэх гол дүрийн Марал бүсгүйг толинд харуулахдаа *эрдэм номын замаар явах уу, Шар бүсгүй шиг амьдралаар амьдрах уу* гэдэг сонголтын өмнө тулгарсан залуу бүсгүйн далд ухамсрыг илэрхийлж, толины бэлгэдлийг зориуд хэрэглэсэн гэж тайлж болно.

Залуу бүсгүйн сэтгэлийн цочрол хийгээд хоёрдмол байдал эцэслэж байгааг зохиолд үзүүлэхдээ ламын хэлснээр биеэс “муу ад”-ыг салгаж байгаа шашны “золиг гаргах” домын зан үйлийн “гурилан хүн”-ийг егөөдөл болгон хэрэглэсэн туршлага сонирхолтой. Марал бүсгүйг уруу татах гэсэн Шар хүүхний явуулгыг зохиолч хоёр, гуравдугаар үзэгдэлдээ илүү хурцатгаж тавьдаг. Шарын занганд орон алдаж цочирдсон Марал бүсгүй Шарын гэрээс зугтан гүйж гэртээ ирэх үед охиныхоо хэвийн биш байгааг харсан өвгөн лам дуудаж, лам түүнд муу ад наалдсан байна гэж оношлоод гурилан хүнээр засал хийлгэдэг. Охины биед наалдсан муу адыг салгаж байгаа ламын домын үйлдэл хийгээд “гурилан зохиомол” бол өмнө өгүүлсэн толийг ашиглан үзүүлсэн хоёрдмол санааг төгсгөхдөө шашны бэлгэдлийг егөөдөл болгон ашигласан сонирхолтой жишээ болно.

Дүгнэлт

С.Буяннэмэхийн уран бүтээл дэх бэлгэдлийн туршлагыг шинжилж үзвэл,

С.Буяннэмэх нь наран сарны гэрэл туяа, хур бороо, солонго, салхи гэх мэт байгалийн үзэгдлээр тэнгэрлэг санааг бэлгэдэх монгол домог зүйн уламжлал хийгээд гарди галбингаа, Бодь мод, Сугаавидийн орон гэх мэт дорно дахины домог зүйн болон буддын шашны бэлгэдлүүдийг, цаашилбал тоть, ирвэс, аалз гэх мэт амьтны дүрийн адилтгал, бэлгэдлийг зохиол бүтээлдээ бүтээлчээр хэрэглэсэн байна.

С.Буяннэмэх нь халагдаж буй хуучин соёлыг хөөрөг тамхи, таяг, гаанс, хятад дэвүүр гэх мэт манж, хятад соёлын эд зүйлс хийгээд тэнгэрийн дүлий, гурилан хүн зэрэг шашны мухар сүсгийн зүйлсийг зохиол бүтээлдээ егөөдөл бэлгэдэл болгон хэрэглэхийн хамтаар шинэ соёл, үзэл суртлыг олон түмэнд сурталчлахдаа талх, ном, барилга байшин, машин зам, нисдэг тэрэг, утас холбоо, толь гэх мэт шинэ соёлын зүйлсийг зохиол бүтээлдээ дүрслэн үзүүлэх замаар монголын уран зохиолд “шинэ” бэлгэдлүүдийг бүтээсэн байна

Summary

The article analyzes the poems and some stories and plays of S. Buyannemekh, the modern Mongolian writer, identifies the experience of using symbols in his writings, and deciphers the main symbols.

Analyzing the symbolic experience in S. Buyannemekh's writings,

1. S. Buyannemekh uses the Mongolian mythological tradition of symbolizing divine ideas with natural phenomena such as sunlight, moonlight, rain, rainbow, wind, and eastern mythological or Buddhist symbols such as gardi galbinga, Bodhi tree, and Land of Sugaavid, and further in his writings, used creatively.

2. S. Buyannemekh uses Chinese culture items such as snuff, cane, long pipe, Chinese fan, and religious superstition items such as “Puffball of Heaven” and “barley dolls” in his writings as ironical symbols of the disappearing culture. To this end, he created new symbols in Mongolian literature by depicting new cultural items such as bread, books, buildings, roads, helicopters, telephones, and mirrors in his short stores and plays while promoting new culture and ideology to the masses.

Ном зүй

- Бүяннэмэх С.** 1968. *Түүвэр зохиол*. Редактор Ц. Мөнх, Улаанбаатар: Монголын зохиолчдын эвлэлийн хэвлэл
- Дулам С.** 2016. *Орчин үеийн уран зохиолыг тэмдэг зүй-бэлгэдэл зүйн үүднээс судлах нь*. ХХ зууны монгол уран зохиол судлалын эрдэм шинжилгээний хурал-II Даяаршил ба нутагшил. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэл. МУШУА-ХЗХ, БНХАУ ӨМИС., Эрхэлсэн С.Байгалсайхан, Б.Мөнхбаяр. Улаанбаатар.
- Уран үгсийн чуулган* (19 дүгээр оны 12-р сард). Хувьсгалын уран зохиолч нарын бүлгэмээс хэвлүүлэв. Улаанбаатар хот: Монгол хэвлэлийн хороо.